НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Дотоод албан хэрэгцээнд

ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

нэг. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар буюу **42-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 12 аймагт **1511** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.

1155
Эмнэлэгийн тусламж авч буцсан

362
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан

23
(Сэжигтэй 1)
Нас барсан



Эр	Эм
728 (47%)	817 (53%)

Хүүхэд (0-17 нас)
650

Насанд хүрэгч (18< нас)
895

Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1545 тохиолдлын 95% /1469/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 5% /76/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /8/, Өмнөговь /3/, Сэлэнгэ /1/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **433** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

42 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.10.11 – 2026.10.17)

2026 оны дөчинхоёрдугаар долоо хоногт угаарын хийн хордлого 44 тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар өссөн бол 5 жилийн дунджаас 31.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-42-р долоо хоногт** нийт **1457** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

660	787	10	ЭМ	ЭР
Эмнэлэгийн тусламж авч буцсан	Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан	Нас барсан	726 (49.5%)	730 (50.5%)



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **дөчинхоёрдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **30** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 6.25 хувиар буурсан бол сүүлийн 5 жилийн дунджаас 30.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (42-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	4	5
2	Эмийн хордлого	10	15	25
Нийт		**11**	**19**	**30**

Нийт 30 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 25 (83%) нь эмийн хордлого, 5 (17%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 19 (63%) тохиолдол, санаатай хордлого 11 (37%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-o0o-